



БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН  
ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2016 оны 11 сарын 10-ны  
өдрийн 148 дугаарт бүртгэв.

2016 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн  
хяналт тавих дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг,  
Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн  
ТУШААХ нь:

1. "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм" /БНБД11-04-16/-ийг хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллагад хүргүүлж мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Занабазар/-т үүрэг болгосугай.
3. Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 185 дугаар тушаалаар баталсан "Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм" /БНБД11-04-15/-ийг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэ тушаалыг 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД  Т.МӨНХБАЯР



08 00572

Барилга, хот байгуулалтын сайдын  
2016 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн  
178 дугаар тушаалын хавсралт

## БАРИЛГЫН АЖИЛД ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТ ТАВИХ ДҮРЭМ

### Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэ дүрмээр Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.32, 38 дугаар зүйлийн 38.1.4, 38.1.8-т заасныг үндэслэн барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт /цаашид “зохиогчийн хяналт” гэх/ тавих ажлын хүрээнд барилгын ажлын захиалагч, барилгын ажил гүйцэтгэгч, зураг төсөл зохиогчийн хүлээх эрх, үүрэг болон зураг төсөл зохиогчоос барилгын ажилд хяналт тавих, үнэлгээ, дүгнэлт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

### Хоёр. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Бүх төрлийн барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах, тоноглох болон хөшөө дурсгал, түүх, соёл, архитектурын дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлахаар гүйцэтгэсэн барилгын ажилд зураг төсөл зохиогчоос хяналт тавих үйл ажиллагаанд энэ дүрмийг мөрдөнө.

### Гурав. ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай / цаашид захиалагч гэх/ гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина. / Хавсралт-№2 Зохиогчийн хяналт гүйцэтгэх гэрээний үлгэрчилсэн загвар/

3.2. Зохиогчийн хяналтыг барилга байгууламжийн байршил, онцлогоос хамааруулан дараах 3 хэлбэрээр гүйцэтгэнэ.

3.2.1. барилгын ажилд байнгын хяналт тавих;

3.2.2. тогтмол хуваарийн дагуу барилгын ажилд хяналт тавих

3.2.3. барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих.

3.3. Зохиогчийн хяналт гүйцэтгэх хэлбэрийг зураг төсөл зохиогч, захиалагч, барилгын ажил гүйцэтгэгч (цаашид талууд гэх) тохиролцож гэрээгээр зохицуулна. Уг гэрээнд дараах нөхцлийг заавал тусгана.

3.3.1. Зохиогчийн хяналт гүйцэтгэгч үүргээ биелүүлэх боломжоор хангагдах, гэрээнд оролцогч талууд харилцан тавьсан шаардлага, үүргийг биелүүлэн ажиллах.

3.3.2. Захиалагчаас барилгын ажил гүйцэтгэгчтэй (ерөнхий болон туслан) хийх гэрээнд зураг төсөл зохиогч, зохиогчийн хяналт гүйцэтгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлэхээр тусгах;

3.3.3. Барилгын ажил эхлэхээс өмнө зохиогчийн хяналт гүйцэтгэгчийн зохион байгуулалт, ажлын гүйцэтгэл, зохиогчийн хяналтын тэмдэглэл хэрхэн хөтлөх /хавсралт №1/ тухай тусгах.

3.4. Зохиогчийн хяналтыг барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

3.5. Барилгын ажил гүйцэтгэгч барилгын ажлын явцад зураг төсөлтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авахдаа зохиогчийн хяналт гүйцэтгэгчид бичгээр хүсэлт гаргана. Зохиогчийн хяналт гүйцэтгэгч бичгээр хариуг өгч, хувийг зохиогчийн хяналтын тэмдэглэлд хавсаргана.

3.6. Эрх бүхий гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан барилга байгууламжийн зураг төслийн зохиогчийн хяналтыг Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д заасны дагуу тухайн барилга байгууламжийн зураг төслийг баталгаажуулсан Монгол улсын зураг төслийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

3.7. Зохиогчийн хяналтыг гүйцэтгэхдээ хяналтын баг бүрдүүлж, ахлагчийг томилно. Багийн ахлагч барилгын зураг төсөл, барилгын ажлын чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн байна.

4.8. Гишүүд зохиогчийн хяналт гүйцэтгэж, багийн ахлагчид дүгнэлт, тайлан бичиж хүлээлгэн өгнө.

3.9. Багийн ахлагч зохиогчийн хяналт тавьсан гишүүдийн дүгнэлтийг нэгтгэж тайланг захиалагч, барилгын ажил гүйцэтгэгчид, хэрвээ зохиогчийн хяналт гүйцэтгэх эрхийг шилжүүлж авсан бол зураг төсөл зохиогч байгууллагад хүлээлгэн өгч танилцуулна.

3.10. Зохиогчийн хяналтын дүгнэлтэд дурьдагдсан зөрчил дутагдлыг арилгах талаар заавар зөвлөмжийг өгч, өмнөх хяналтаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгасан талаар захиалагч, барилгын ажил гүйцэтгэгчээс тайлан гаргуулна.

3.11. Нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөлд холболт хийсэн зураг төсөл зохиогч байгууллага нь тухайн зураг төслөөр баригдсан барилга байгууламжийн барилгын ажилд зохиогчийн хяналтыг гүйцэтгэнэ.

## **Дөрөв. ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

4.1. Зохиогчийн хяналт гүйцэтгэгч дараахь эрх эдэлнэ:

4.1.1. барилгын ажлын талбайд нэвтрэх;

4.1.2. хяналтын ажил гүйцэтгэхэд аюул, эрсдэл байна гэж үзвэл хяналт хийхээс татгалзаж, зөрчлийг арилгуулж, аюулгүй байдлыг хангуулсны дараа хяналт тавих;

4.1.3. барилга байгууламжийн баримт бичиг, барилгын ажил гүйцэтгэж байгаа техникийн баримт бичигтэй танилцах;

4.1.4. барилгын ажлын дэвшилтэд шийдэл гаргах, барилгын чанар, эрүүл ахуй, галын аюулгүй байдалд нөлөөлөхөөргүйгээр архитектур төлөвлөлтийг ашиглалтын нөхцөлтэй уялдуулан боловсронгуй болгож, барилгын өртгийг бууруулах, чанарыг сайжруулах, угсралтын хугацааг богиносгох, барилгын үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгохоор санал өгөх;

4.1.5. барилгын материал, технологийн тоног төхөөрөмж, машин механизмыг ижил төстэй, тохирох өөр материал, тоног төхөөрөмж, машин механизмаар солих;

4.1.6.барилгын ажил гүйцэтгэх явцад зохиогчийн хяналт гүйцэтгэгчээс өгсөн үүрэг, даалгавар, “Зохиогчийн хяналтын тэмдэглэл”-д /Хавсралт №1/ бичигдсэн зөвлөмж, шаардлагын биелэлтийг хянах;

4.1.7.барилга байгууламжийн бүтээц, материал, хийц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр тодорхойлуулж, баталгаажуулахыг захиалагчаас шаардах, түүнд үндэслэн дүгнэлт гаргах;

4.1.8.барилга байгууламжийн бат бэх, найдваржилт, экологи, чанарын шаардлагыг бууруулахгүйгээр барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээц, материал, бүтээгдэ-хүүнийг өөрчлөх;

4.1.9.улсын стандарт, техникийн нөхцөл хангахгүй материал, эдлэл, тоног төхөөрөмж хэрэглэхийг хориглох;

4.1.10. чанаргүй гүйцэтгэсэн барилгын ажлыг шаардлагатай түвшинд хүргэж засах талаар барилгын ажил гүйцэтгэгч, захиалагчийн боловсруулсан техникийн шийдлийг хянан шийдэх;

4.1.11.чанаргүй гүйцэтгэсэн барилгын ажлыг засах шаардлагыг барилгын ажил гүйцэтгэгч, захиалагч байгууллагад тавих;

4.1.12.шаардлагатай тохиолдолд барилгын ажлыг зогсоох шаардлагыг барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад тавих;

4.1.13.барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц,бүтээц, материалд болон инженерийн шугам сүлжээний хэмжээ, хүчин чадалд өөрчлөлт оруулсан бол зураг төслийг /гүйцэтгэлийн зураг төсөл/ дахин боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг шинээр авахыг захиалагч, гүйцэтгэгчээс шаардах;

4.1.14. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажиллагаанд оролцох.

## 4.2. Зохиогчийн хяналт гүйцэтгэгч дараахь үүргийг хүлээнэ:

4.2.1.захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр барилгын ажилд зохиогчийн хяналт тавих;

4.2.2.барилгын хөрөнгө оруулагч, захиалагч, барилгын ажил гүйцэтгэгчид барилга байгууламжийн баримт бичигтэй танилцахад туслалцаа үзүүлэх;

4.2.3.барилгын ажлыг норм нормативын баримт бичиг, ажлын зургийн дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянах;

4.2.4.барилгын материал, тоног төхөөрөмж, бүтээц, эдлэхүүн, бүтээгдэхүүнийн сертификат, паспорт, бусад техникийн бичиг баримтууд нь улсын стандарт, техникийн нөхцөл, зураг төслийн баримт бичигтэй тохирч байгаа эсэхийг хянах;

4.2.5.хэрэглэж буй материал, бүтээц, эдлэлийн чанар улсын стандартын шаардлага, зураг төсөл, туршилт, лабораторийн шинжилгээний үр дүн, паспортын үзүүлэлттэйгээ тохирч байгаа эсэхийг хянах;

4.2.6.барилга үйлдвэрлэлийн технологийн мөрдөлт, барилга, байгууламжийн бат бэх, тогтвортой байдал, эдэлгээний зэргийг хангуулах,

технологийн ба инженерийн тоног төхөөрөмжийн угсралтын ажлын чанар байдалд шалгалт хийх;

4.2.7.барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төслийг хэрэгжүүлж, барилгын ажил норм, дүрэм, үйлдвэрлэлийн технологийн дагуу хийгдэж байгаа эсэхийг хянах;

4.2.8.ажлын зургийн өөрчлөлтийг “Ажлын зурагт тавигдах ерөнхий шаардлага”-ын дагуу боловсруулж гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавих;

4.2.9.зохиогчийн хяналт гүйцэтгэж байх үед гаргасан техникийн шийдлүүдийн дагуу зураг төслийн баримт бичгийн өөрчлөлтийг тухай бүрд нь боловсруулах, архивт хадгалуулах;

4.2.10.зохиогчийн хяналт гүйцэтгэгчийн өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаа алдаж, чанаргүй гүйцэтгэж буй тухай мэдээллийг захиалагчид өгөх;

4.2.11.барилга байгууламжийн ашиглалтын зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохирлыг хариуцах;

4.2.12.зохиогчийн хяналт хийж байгаа мэргэжилтнүүдээ амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулсан байх.

4.3. Зохиогчийн хяналт гүйцэтгэгч нь зохиогчийн хяналтын тэмдэглэлийн /хавсралт №1/ “Зураг төслийн байгууллагын шаардлага” гэсэн хэсэгт дор дурдсан зүйлүүдийг тэмдэглэнэ:

4.3.1.илэрсэн зөрчил, гэмтэл, түүний шалтгаан, арилгах арга зам, засварлах хугацааг заах;

4.3.2.өмнө өгсөн даалгаврын биелэлтийг шалган шаардлагатай тохиолдолд шинээр даалгавар өгөх.

4.4. Зохиогчийн хяналт гүйцэтгэгч барилгын талбайд мөрдөгдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны холбогдох дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

### **Тав. ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ, ДҮГНЭЛТ**

5.1. Барилгын хүчин чадал, технологийн шийдэл, барилга байгууламжын ажил гүйцэтгэгч, захиалагч нарын мэргэжлийн ур чадвар, барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх хугацаа, энэ дүрмийн 3.2-т заасан хяналт хэрэгжүүлэх хэлбэр зэргээс хамааруулан захиалагч, зохиогчийн хяналт гүйцэтгэгч нар Зохиогчийн хяналтын үр дүн, зөвлөмж, шаардлагыг тэмдэглэх баримт бичгийн сонголт, бүрдлийг хамтран шийдэж, Зохиогчийн хяналтын гэрээнд /хавсралт №2/ тодорхой зааж өгнө.

5.2. Зохиогчийн хяналт гүйцэтгэсэн тэмдэглэл, бусад ашигласан маягтуудын хуулбар хувийг зохиогчийн хяналтын тэмдэглэлд хавсаргана Зохиогчийн хяналтын тэмдэглэл дараахь хэсгүүдээс бүрдэнэ:

5.2.1.Барилга байгууламжийн мэдээллийг Хавсралт №1-ийн Хүснэгт 1-ийн дагуу тэмдэглэнэ;

5.2.2.Захиалагчийн мэдээллийг Хавсралт №1-ийн Хүснэгт 2-ын дагуу тэмдэглэнэ;

5.2.3.Барилгын ажил гүйцэтгэгчийн мэдээллийг Хавсралт №1-ийн Хүснэгт 3-ын дагуу тэмдэглэнэ;

5.2.4.Туслан гүйцэтгэгчийн мэдээллийг Хавсралт №1-ийн Хүснэгт 4-ийн дагуу тэмдэглэнэ;

5.2.5.Зохиогчийн хяналт гүйцэтгэгчийн мэдээллийг Хавсралт №1-ийн Хүснэгт 5-ын дагуу тэмдэглэнэ;

5.2.6. Зохиогчийн хяналт гүйцэтгэгч багийн гишүүдийн мэдээллийг Хавсралт №1-ийн Хүснэгт 6-ийн дагуу тэмдэглэнэ;

5.2.7. Зохиогчийн хяналт гүйцэтгэсэн тухай бүртгэлийн мэдээллийг Хавсралт №1-ийн Хүснэгт 7-ийн дагуу тэмдэглэнэ;

5.2.8 Зохиогчийн хяналтын явцад захиалагч, барилгын ажил гүйцэтгэгчээс тодруулсан асуудлыг шийдвэрлэсэн бичиг баримтын бүртгэлийг Хавсралт №1-ийн Хүснэгт 8-ийн дагуу тэмдэглэнэ;

5.2.9 Зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг арилгасан тухай бүртгэлийг Хавсралт № 1-ийн Хүснэгт 9-ийн дагуу тэмдэглэнэ.

5.3. Барилгын ажлыг зураг төсөл, норм нормативийн баримт бичгийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг хянахдаа энэ дүрмийн Хавсралт №1-ийн 10-аас 43 дугаар хүснэгтүүдэд заасан шалгах хуудас ашиглана. Шалгах хуудсанд тусгагдсан ажилбаруудыг барилга байгууламжийн онцлогт тохируулан өөрчлөн хэрэглэж болно.

5.4. Шалгах хуудсанд зураг төслөөс өөрчилж гүйцэтгэсэн ажил, түүнтэй холбоотой мэдээллийг бичнэ. Нэгээс дээш хуудастай шалгах хуудас бичсэн тохиолдолд хуудсын тоог заана.

5.5. Хуудас бүрт оролцогч талууд гарын үсэг зурж баталгаажуулна. Мөн барилгын ил, далд ажлуудын актыг баримтжуулсан фото зураг, хэмжилт туршилт хийсэн актын үнэн зөв, эсэхийг хянаж дүгнэлтэд тусгана.

5.6. Зохиогчийн хяналт гүйцэтгэгч урьд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хянаж дүгнэлтэд тусгана. Шаардлагатай гэж үзвэл технологи, төлөвлөлтийн шийдлийг хянаж болно.

5.7. Барилгын төрөл, технологийн горим, бүтээц, эдэлхүүнийн шийдлээс хамааруулан зохиогчийн хяналт гүйцэтгэгч нэмэлт маягтыг барилгын ажил гүйцэтгэгч, захиалагчтай зөвшилцөн боловсруулж барилгын ажлын явцад ашиглаж болно.

5.8. Зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлтийг зохиогчийн хяналтын тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн боловсруулна.

5.9. Зохиогчийн хяналтын тэмдэглэлийн эх хувийг барилга байгууламжийг ашиглалтанд оруулах үед барилга байгууламжийн баримт бичгийн хамт архивт хүлээлгэн өгнө.

## **Зургаа. ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫН АЖЛЫН ҮНЭЛГЭЭ**

6.1. Зохиогчийн хяналт гүйцэтгэгчийн ажлын үнэлгээг хяналт хийх төрлөөс нь хамааруулж захиалагчтай зөвшилцөж тогтооно.

6.2. Захиалагч, барилгын ажил гүйцэтгэгчийн хүсэлтээр зураг төсөлд оруулсан өөрчлөлтийн үнийг зохиогчийн хяналтын ажлын үнэлгээнд хамааруулахгүй.

6.3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих барилга байгууламжид зохиогчийн хяналт гүйцэтгэх томилолтын зардлыг тооцохдоо Монгол улсын Засгийн газар, Сангийн сайдын тушаалаар баталсан үнэ тарифийг жишиг болгон авна. Бусад тохиолдолд дотоодын тээврийн зардал, байр, хоолны үнийг тухайн орон нутгийн жишиг үнээс хамааруулан захиалагч, зохиогчийн хяналт гүйцэтгэгч нар харилцан тохиролцож тогтооно.

**ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ**

Гэрээний дугаар: .....

Зохиогчийн хяналтын тэмдэглэл дугаар: .....

Барилгын төслийн нэр:

.....  
.....  
.....  
.....

“Зураг төслийн байгууллагын шаардлага”

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Зохиогчийн хяналт гүйцэтгэгч:

.....  
.....

Агуулга:

1. Барилга байгууламжийн мэдээлэл
2. Барилгын ажлын захиалагчийн мэдээлэл
3. Барилгын ажил гүйцэтгэгчийн мэдээлэл
4. Зохиогчийн хяналт гүйцэтгэгчийн мэдээлэл
5. Зохиогчийн хяналтын гүйцэтгэлийн бүртгэл
6. Шаггах хуудсууд



## 1. Барилга байгууламжийн мэдээлэл

Хүснэгт 1

№	Барилга байгууламжийн мэдээлэл	
1	Барилга байгууламжийн нэр	
2	Барилга байгууламжийн байршил, хаяг	
3	Зураг төслийн шифр	
4	Зураг төслийг хянасан байгууллага, батагсан огноо	
5	Төслийн хөрөнгө оруулалтын хэлбэр	
6	Төслийн төсөвт өртөг	
7	Төслийг эхэлсэн огноо	
8	Төслийг хэрэгжүүлэх хугацаа	
9	Төслийг дуусгах хугацаа	
10	Бусад мэдээлэл	

## 2. Барилгын ажлын захиалагчийн мэдээлэл

## Хүснэгт 2

№	Барилгын ажлын захиалагч байгууллагын мэдээлэл	
1	Байгууллагын нэр	
2	Улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар	
3	Байгууллагын хаяг	
4	Холбоо, цахим хаяг	
	Захиалагчийн төлөөлөгч:	
5	Овог, нэр:	
6	Албан тушаал:	
7	Холбоо барих утас. Цахим хаяг:	
8	<i>Гарын үсэг</i>	

## 3. Барилгын ажил гүйцэтгэгчийн мэдээлэл

## Хүснэгт 3

1	Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч байгууллагын мэдээлэл	Байгууллагын нэр	
2		Улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар	
3		Байгууллагын хаяг	
4		Тусгай зөвшөөрлийн дугаар, хугацаа	
5		Холбоо, цахим хаяг	
6	Ерөнхий гүйцэтгэгчийн төлөөлөгч	Овог, нэр:	
7		Албан тушаал:	
8		Холбоо барих утас.	
9		<i>/Гарын үсэг/</i>	
10		Барилга угсралтын ажлын гэрээний дугаар:	
11		Барилга угсралтын ажлыг эхэлсэн огноо:	
12		Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацаа:	
13		Барилга угсралтын ажлыг дуусгасан огноо:	
14	Барилга ажлын туслан гүйцэтгэгч байгууллага	Байгууллагын нэр:	
15		Улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар:	
16		Байгууллагын хаяг:	
17		Холбоо, цахим хаяг, тамга	
18	Туслан гүйцэтгэгчийн төлөөлөгч	Овог, нэр:	
19		Албан тушаал:	
20		Холбоо барих утас. Цахим хаяг:	
21		<i>/Гарын үсэг /</i>	



## 4. Зохиогчийн хяналт гүйцэтгэгчийн мэдээлэл

## Хүснэгт 5

1	Зураг төсөл зохиогч байгууллага	Байгууллагын нэр	
2		Улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар	
3		Байгууллагын хаяг	
4		Тусгай зөвшөөрлийн төрөл. дугаар, хугацаа	
5		Холбоо, цахим хаяг ( <i>тамга</i> )	
6	Зураг төсөл зохиогчийн туслан гүйцэтгэгч	Байгууллагын нэр	
7		Улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар	
8		Байгууллагын хаяг	
9		Тусгай зөвшөөрлийн төрөл. дугаар, хугацаа	
10		Холбоо, цахим хаяг ( <i>тамга</i> )	
11	Зохиогчийн хяналт гүйцэтгэгч	Байгууллагын нэр	
12		Улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар	
13		Байгууллагын хаяг	
14		Тусгай зөвшөөрлийн төрөл. дугаар, хугацаа	
15		Холбоо, цахим хаяг	
16	Зохиогчийн хяналт гүйцэтгэгчийн туслан гүйцэтгэгч	Байгууллагын нэр	
17		Улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар	
18		Байгууллагын хаяг	
19		Тусгай зөвшөөрлийн төрөл. дугаар, хугацаа	
20		Холбоо, цахим хаяг	
21		Зохиогчийн хяналт гүйцэтгэх хэлбэр	
22		Зохиогчийн хяналт хийж эхэлсэн огноо	
23		Зохиогчийн хяналт гүйцэтгэх хугацаа	
25		Зохиогчийн хяналт хийж дууссан огноо	

## Зохиогчийн хяналт гүйцэтгэгч багийн гишүүдийн мэдээлэл

## Хүснэгт 6.

№	Овог нэр	Мэргэжлийн дэв, зэрэг	Зохиогчийн хяналт хийх ажлын чиглэл	Холбоо барих утас, цахим хаяг
1	2	3	4	5

*Тайлбар: Тухайн барилга дээр зохиогчийн хяналт гүйцэтгэж байгаа бүх ажилтнууд (Багийн удирдагч, барилга бүтээцийн инженер, ЦБУ-ны инженер, ХАС-ын инженер, цахилгаан хангамж холбоо дохиоллын инженер гэх мэт ) энэхүү хүснэгтэд бичигдэнэ. Хүснэгтийг зохиогчийн хяналтын багийн удирдагч хөтөлж бичнэ.*



**ХАВСРАЛТ № 1****Зохиогчийн хяналтын явцад захиалагч, барилгын ажил гүйцэтгэгчээс тодруулсан асуудлыг шийдвэрлэсэн бичиг баримтын бүртгэл.****Хүснэгт 8**

№	Илгээсэн бичиг баримтын код, дугаар	Илгээсэн огноо	Тухайн бичиг баримтыг бичсэн зорилго	Асуудлын товч утга	Асуудлыг анх илгээсэн ба хариу бичсэн хүний овог нэр, албан тушаал бусад мэдээлэл	
					Хариулсан Зохиогч	Асуултыг илгээгч
1	2	3	4		5	6

*Тайлбар: Асуудлыг илгээгчийн овог, нэр, албан тушаалыг 6-р багананд, заавар зөвлөгөө өгсөн зохиогчийн хяналт гүйцэтгэгчийн овог, нэр, албан тушаалыг хүснэгтийн 5-р багананд бичнэ. Шаардлагатай бол гарын үсэг зуруулна. Холбогдох ТХХ (тодруулга хүсэх хуудас) ба ЗЗХ (зохиогчийн зөвлөмжийн хуудас) энэхүү зохиогчийн хяналтын тэмдэглэлд хавсрагдана.*



**ХАВСРАЛТ № 1****Зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг арилгасан тухай бүртгэлийн хуудас.****Хүснэгт 9**

№	Илэрсэн алдаа, зөрчлийн товч утга	Алдаа, зөрчлийг тэмдэглэсэн бичиг баримтын дугаар, огноо	Алдаа, зөрчлийг зассан тухай биелэлтийг хянасан зохиогчийн овог нэр	Алдаа, зөрчлийг арилгах зааврыг хүлээн авч, биелүүлсэн төлөөлөгчийн овог нэр, гүйцэтгэсэн огноо	
				Биелэлтийг баримжуулсан баримтын дугаар	Гүйцэтгэгчийн Овог нэр Он сар өдөр
1	2	3	4	5	6

*Тайлбар: Гарсан алдаа, зөрчлийг засаж арилгасан байдалтай танилцаж, биелэлтийг хянасан зохиогчийн нэрийг багана 4-т, шаардлагыг хүлээж авч ажлыг гүйцэтгэсэн хүний овог, нэр, албан тушаалыг 6-р баганад бичнэ. Алдаа зөрчлийг засаж, арилгаагүй нөхцөлд багана 5-д тэмдэглэнэ.*

## 6. Шалгах хуудсууд

## Хүснэгт 10

ЕТ	ШАЛГАХ ХУУДАС № ЕТ-001		Огноо: 2015-03-12 Гэрээний №: 2014/01
Тохижилт			
Төслийн нэр:	Иргэн Ч.Барсболдын орон сууцны барилга	Хаяг, байршил:	УБ хот. ХУД-ийн 4-р хороо.
Шалгах хэсэг:	Г адна тал	Зургийн марк:	ЗТ-2014-01 /ЕТ 101, ЕТ 102
Шалгалтын үе	2 дахь шалгалт	Техникийн тодорхойлолт №:	201 5-ЕТ-01
Хавсралттай эсэх: <input type="checkbox"/> тийм /товч тайлбар/ ..... <input type="checkbox"/> үгүй			
1. Ажил шалгах үзүүлэлт:		Зургийн дагуу хийгдсэн эсэх:	
1.1	Гадна гэрэлтүүлэг	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
1.2	Явган зам	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
1.3	Авто зам	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
1.4	Авто зогсоол	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
1.5	Замын хашлага	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
1.6	Үерийн ус зайлуулах налуулга, өндөржилт	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
1.7	Үерийн ус зайлуулах суваг	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
1.8	Хүүхдийн тоглоомын талбай	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
1.9	Ногоон байгууламж	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
1.10	Мод, бут	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
1.11	Хашаа	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
2. Материалын үзүүлэлт:			
2.1	Явган замын хавтан	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
2.2	Бетон зам	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
2.3	Асфалт зам	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
2.4	Хашлага бетон Хашаа	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
2.5		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
2.6	-----	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
2.7		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
2.8		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
2.9		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
3. Буса д:		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
3.1		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
3.2			
3.3		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
3.4		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
3.5		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй	
Дүгнэлт :		<input type="checkbox"/> Зөвшөөрсөн <input type="checkbox"/> Зөвшөөрөхгүй	
Тайлбар:			



2.6	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3. Бусад:			
3.1			
3.2			
3.3			
Дүгнэлт :		<input type="checkbox"/> Зөвшөөрсөн	<input type="checkbox"/> Зөвшөөрөхгүй
Тайлбар:			
Шалгасан:	Зохиогч :	Захиалагч:	БУ Гүйцэтгэгч:
Нэр			
Албан тушаал			
Байгууллага			
Г арын үсэг			

## ХАВСРАЛТ № 1

### Хүснэгт 12

ГД	ШАЛГАХ ХУУДАС № ГД-002			Огноо: 2015-03-12
Гадна дулаан 2				Г эрээний №: 201 4/01
Төслийн нэр:	Иргэн Ч.Барсболдын орон сууцны барилга	Хаяг, байршил:	УБ хот. ХУД-ийн 4-р хороо.	
Шалгах хэсэг:	Гадна тал	Зургийн марк:	ЗТ-2014-01 /ГД 102~105	
Шалгалтын үе	2 дахь шалгалт	Техникийн тодорхойлолт №:	2015-ГД-102~ 105	
Хавсралттай эсэх:	<input type="checkbox"/> тийм /товч тайлбар/			<input type="checkbox"/> үгүй
1. Ажил шалгах үзүүлэлт:		Зургийн дагуу хийгдсэн эсэх:		
1.4	Дулааны худгийн хэмжээ			
	Худгийн хучилтын дээд талаас газрын хөрсний	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
	Төлөвлөлтийн түвшин хүртэлх зай	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
	Люкний тоо	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
	Дулаалгатай хоолой худгийн хийц хоорондын зай	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
	Таслаххаалт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
	Юүлэх хаалт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
	Хий гаргах хаалт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.5	Зөөлөвч			
	Төрөл	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
	Таталт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.6	Г улгах тулгуурын			
	Төрөл	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
	Зай	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
	Байршил	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
	Чанар	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.7	Үл хөдлөх тулгуур			
	Чанар	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй

Төрөл	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
Зай	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
Байршил	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.8 Үл хөдлөх тулгуурын үндсэн хийц	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2. Материалын үзүүлэлт:			
2.1 Г ан яндан	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.2 Дулаалга	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.6 Барилгын бүтээцийн материал	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3. Бусад:			
3.1			
3.2			
3.3	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
Дүгнэлт :	<input type="checkbox"/> Зөвшөөрсөн	<input type="checkbox"/> Зөвшөөрөхгүй	
Тайлбар:			
Шалгасан:	Зохиогч :	Захиалагч:	БУ Гүйцэтгэгч:
Нэр			
Албан тушаал			
Байгууллага			
Г арын үсэг			

## ХАВСРАЛТ № 1

### Хүснэгт 13

ГЦ	ШАЛГАХ ХУУДАС № ГЦ-001		Огноо: 2015-03-12
Гадна цахилгаан			Г эрээний №: 2014/01
Төслийн нэр:	Иргэн Ч.Барсболдын орон сууцны барилга	Хаяг, байршил:	УБ хот. ХУД-ийн 4-р хороо.
Шалгах хэсэг:	Г адна тал	Зургийн марк:	ЗТ-201 4-01/ГЦ 102
Шалгалтын үе шат	2 дахь шалгалт	Техникийн тодорхойлолт №:	2015-ГЦ-1 02
Хавсралттай эсэх:	<input type="checkbox"/> тийм /товч тайлбар/		.... <input type="checkbox"/> үгүй
1. Ажил шалгах үзүүлэлт:		Зургийн дагуу хийгдсэн эсэх:	
1.1 Дэд өртөө:	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.2 Трансформатор: холболт, зайлуулах зам, зай хэмжээ	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.3 Яйчейка	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.4 10-6кВ тэжээлийн бүдүүвч	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.5 0.4 кВ гаргалгааны бүдүүвч	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.6 10-6 кВ ХБ-ийн захиалгын хуудас	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.7 0.4 кВ ХБ-ийн захиалгын хуудас	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.8 Г азардуулга	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.9 Аянга хамгаалалт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй

1.10	10-6 кВ кабель, трасс, тавих гүн, муфт, хамгаалалт, үзүүрлэлгээ	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.11	0.4 кВ кабель, трасс, тавих гүн, муфт, хамгаалалт, үзүүрлэлгээ	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.12		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
<b>2. Материалын үзүүлэлт:</b>			
2.1	Кабель 10-6 кВ: материал, огтлол, тусгаарлагч	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.2	Кабель 0.4 кВ: материал, огтлол, тусгаарлагч	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.3	Трансформатор: хүчдэл, чадал, хөргөлт	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.4	ЦО: зориулалт, тавил А		
2.5	КСО: зориулалт, тавил А		
2.6	Гэрэлтүүлэгч: зориулалт, 1P	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.7	Халаалт, агаар сэлгэлт байгаа эсэх	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.8	Кабелийн үзүүлэлгээ	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
<b>3. Бусад:</b>			
3.1	Тусгай зөвшөөрөл	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.2	Газардуулгын акт	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.3	Далд ажлын акт		
3.4	Гүйцэтгэлийн зураг		
3.5	Угсралтын үеийн фото зураг	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.6	Т/т сертификат	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.7	Кабелийн хэмжэлтийн акт	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
Дүгнэлт :		<input type="checkbox"/> Зөвшөөрсөн	<input type="checkbox"/> Зөвшөөрөхгүй
Тайлбар:			
Шалгасан:	Зохиогч :	Захиалагч:	БУ Гүйцэтгэгч:
Нэр			
Албан тушаал			
Байгууллага			
Г арын үсэг			

## ХАВСРАЛТ № 1

### Хүснэгт 14

ГЦ	ШАЛГАХ ХУУДАС № ГЦ-002		Огноо: 2015-03-12
Гадна гэрэлтүүлэг			Г эрээний №: 2014/01
Төслийн нэр:	Иргэн Ч.Барсболдын орон сууцны барилга	Хаяг, байршил:	УБ хот. ХУД-ийн 4-р хороо.
Шалгах хэсэг:	Г адна тал	Зургийн марк:	ЗТ-201 4-01/ГЦ 102~104
Шалгалтын үе шат	2 дахь шалгалт	Техникийн тодорхойлолт №:	2015-ГЦ-1 105 02~
Хавсралттай эсэх:	<input type="checkbox"/> тийм /товч тайлбар/		<input type="checkbox"/> үгүй
1. Ажил шалгах үзүүлэлт:		Зургийн дагуу хийгдсэн эсэх:	
1.1	Гэрлийн самбар: Автоматууд, бирк, бүдүүвч, суурилуулалт,	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй

кабелийн гаргалгаа, чангалгаа, 1P				
1.2	Гэрэлтүүлгийн шон	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.3	ГГ бүдүүвч, шугамын трасс	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.4	0.4 кВ кабель, трасс, тавих гүн, муфт, хамгаалалт, үзүүрлэлгээ	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.5	0.4 кВ агаарын шугам кабель, трасс, татах өндөр, уналт, хамгаалалт, бэхлэлгээ	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.6	Газардуулга	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.7	Аянга хамгаалалт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.8		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.9		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.10		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.11		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2. Материалын үзүүлэлт:				
2.1	Гэрэлтүүлэгч, 1P, зориулалт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.2	Цахилгааны утас, шугам, огтлол, материал	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.3	Гэрэлтүүлгийн шон, хийц, суурилуулалт, газардуулга, бэхлэлгээ	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.4	Гэрэлтүүлгийн удирдлага	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.5		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.6		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.8		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3. Бусад:				
3.1	Тусгай зөвшөөрөл	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.2	Далд ажлын акт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.3	Т/т сертификат	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.4	Гүйцэтгэлийн зураг	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.5	Угсралтын үеийн фото зураг	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.6	Газардуулгын акт			
3.7	Кабелийн хэмжэлтийн акт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
38		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
Дүгнэлт :		<input type="checkbox"/> Зөвшөөрсөн	<input type="checkbox"/> Зөвшөөрөхгүй	
Тайлбар:				
Шалгасан:	Зохиогч :	Захиалагч:	БУ Гүйцэтгэгч:	
Нэр				
Албан тушаал				
Байгууллага				
Гарын үсэг				

# ХАВСРАЛТ № 1

## Хүснэгт 15

<b>ГХ</b>	<b>ШАЛГАХ ХУУДАС № ГХ-001</b>			Огноо: 2015-03-12 Гэрээний №: 2014/01
<b>Гадна холбоо</b>				
Төслийн нэр:	Иргэн Ч.Барсболдын орон сууцны барилга	Хаяг, байршил:	УБ хот. ХУД-ийн 4-р хороо.	
Шалгах хэсэг:	Г адна тал	Зургийн марк:	ЗТ-201 4-01/ГХ 102	
Шалгалтын үе шат	2 дахь шалгалт	Техникийн тодорхойлолт №:	2015-ГХ-102	
Хавсралттай эсэх:	<input type="checkbox"/> тийм /товч тайлбар/ ..... <input type="checkbox"/> үгүй			
<b>1. Ажил шалгах үзүүлэлт:</b> ..... Зургийн дагуу хийгдсэн эсэх:				
1.1	Гадна холбооны оролт	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.2	Сувагчлалаар сүвлэх	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.3	Г үүрээр сүвлэх Газарт сүвлэх	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.4	Барилгын ханаар суурилуулах	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.5		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.6	Баганаар өлгөх	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.7	Зогсуураар өлгөх	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.8	Шилэн кабель	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.9	Кабелийн яндан хоолой	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.10	Тусгаарлах тууз	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.11	Таних тэмдэг, тэмдэглэгээ	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.12	Оролтын самбарын тоноглол	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.13	Худгийн дугаар Баганы	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
1.14	дугаар	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
<b>2. Материалын үзүүлэлт:</b>				
2.1	Оролтын самбарын тоноглол, 1P	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
2.2	Кабель: материал, огтлол, тусгаарлагч Шилэн кабель	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
2.3		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
2.4	Кабелийн тавиур	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
2.5	Кабелийн яндан хоолой	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
2.6		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
<b>3. Бусад:</b>				
3.1	Тусгай зөвшөөрөл Т/т	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
3.2	сертификат Далд ажлын акт	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
3.3		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
3.4	Гүйцэтгэлийн зураг	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
3.5	Угсралтын үеийн фото зураг	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/> шаардлагагүй		
Дүгнэлт : <input type="checkbox"/> Зөвшөөрсөн <input type="checkbox"/> Зөвшөөрөхгүй				
Тайлбар:				
Шалгасан:	Зохиогч :	Захиалагч:	БУ Гүйцэтгэгч:	
Нэр				



Албан тушаал			
Байгууллага			
Г арын үсэг			

## ХАВСРАЛТ № 1

### Хүснэгт 16

УХАТ	ШАЛГАХ ХУУДАС № УХАТ-001			Огноо: 2015-03-12
Ариутгах татуурга				Г эрээний №: 2014/01
Төслийн нэр:	Иргэн Ч.Барсболдын орон сууцны барилга	Хаяг, байршил:	УБ хот. ХУД-ийн 4-р хороо.	
Шалгах хэсэг:	2-р давхар	Зургийн марк:	ЗТ-2014-01/ХАС 102~105	
Шалгалтын үе шат	2 дахь шалгалт	Техникийн тодорхойлолт №:	2015-ХАС-102 ~105	
Хавсралттай эсэх:	<input type="checkbox"/> тийм /товч тайлбар/			.... <input type="checkbox"/> үгүй
1. Ажил шалгах үзүүлэлт:		Зургийн дагуу хийгдсэн эсэх:		
1.1	Төлөвлөлт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.2	Трас сонголт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.3	Техникийн нөхцөл	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.4	Хөрсний шинж чанар	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.1	Яндан хоолойн угсралт			
2.2	Холбогдох худаг	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.3	Холболтын түвшин	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.4	Налуу	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.5	Холболтын төрөл	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.6	Г эрэвч хоолой	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.7	Элсэн дэвсгэр	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.1	Худаг			
3.2	Худгийн гүн	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.3	Дулаалга	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.4	Уналт	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.2	Ул бетон	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.3	Таг	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.4	Хүзүүвч	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.5	Шат	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.6	Модон таг	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.7		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.9		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2. Материалын үзүүлэлт:				
2.2	Яндан хоолой	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.3	Яндан хоолойн дулаалга:	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.4	Худаг	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.5	Г эрэвч хоолой	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.6		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.7		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3. Бусад:				

3.1		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.21		<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
Дүгнэлт :		<input type="checkbox"/> Зөвшөөрсөн	<input type="checkbox"/> Зөвшөөрөхгүй	
Тайлбар:				
Шалгасан:	Зохиогч :	Захиалагч:	БУ Г үйцэтгэгч:	
Нэр				
Албан тушаал				
Байгууллага				
Г арын үсэг				

## ХАВСРАЛТ № 1

### Хүснэгт 17

УХАТ	ШАЛГАХ ХУУДАС № УХАТ-002			Огноо: 2015-03-12
Ус хангамж				Г эрээний №: 2014/01
Төслийн нэр:	Иргэн Ч.Барсболдын орон сууцны барилга	Хаяг, байршил:	УБ хот. ХУД-ийн 4-р хороо.	
Шалгах хэсэг:	2-р давхар	Зургийн марк:	ЗТ-2014-01/ХАС 102~105	
Шалгалтын үе шат	2 дахь шалгалт	Техникийн тодорхойлолт №:	2015-ХАС-102 ~105	
Хавсралттай эсэх:	<input type="checkbox"/> тийм /товч тайлбар/			... <input type="checkbox"/> үгүй
1. Ажил шалгах үзүүлэлт:		Зургийн дагуу хийгдсэн эсэх:		
1.1	Төлөвлөлт			
1.2	Унд ахуй	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.3	Гал эсэргүүцэх	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
1.4	Үйлдвэрлэлийн	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.1	Яндан хоолойн угсралт			
2.2	Холбогдох худаг	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.3	Холболтын түвшин	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.4	Налуу	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.5	Холболтын төрөл	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.6	Г эрэвч хоолой	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.7	Холболтын чанар	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
2.8	Элсэн дэвсгэр	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
3.1	Худаг			
3.2	Худгийн гүн	<input type="checkbox"/> тийм	<input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> шаардлагагүй
